

ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

/Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол/

2011.03.11

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал		
<p>1.1.Дараах зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> -байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; -албан хаагчийн ёс зүйн дүрэм; -төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; -төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт; -байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар. 	<p>Сэлэнгэ аймгийн албан ёсны www.selenge.mn цахим хуудсаар аймгийн танилцуулга, нутгийн удирдлагын байгууллагын бүтэц, үйл ажиллагааны үндсэн чиглэл, орон нутгийн захиргаа, төр, төсвийн байгууллагуудын мэдээллийг байршуулан аймгаас баримталж буй бодлого шийдвэр, төсөл, хөтөлбөр, цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн иргэдэд ил тод, нээлттэй хүргэн ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн мэдээллийн самбарт байгууллагын эрхэм зорилго, бүтэц, бодлогын хэлтсүүдийн үндсэн чиг үүрэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын шийдвэр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэр, Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд заасан төрийн захиргааны албан хаагчийн тангараг, нийтлэг эрх үүргийг нийтэд нээлттэй байдлаар байршуулж, тогтмол шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сумд, агентлагуудад хүргүүлэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдэд хувиалан өгч, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээнд ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллах талаар тусгайлан заалт болгон оруулж, шуурхай байдал, ёс зүйг дээшлүүлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар аймгийн Засаг дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн даргын үүрэг даалгаврыг нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, нийт төрийн албан хаагчдад өгч хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын үүдний танхимд LCD дэлгэцийг байрлуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын зураг, овог нэр, албан тушаал, хариуцах асуудал, холбоо барих утас, ерөөний дугаар бүхий дэлгэрэнгүй мэдээллийг дүрсжүүлсэн богино хэмжээний видео танилцуулгыг гаргаж, иргэд, үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх боломж нөхцлийг бүрдүүллээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар аймгийн цахим хуудас, Тамгын газрын мэдээллийн самбар, LCD дэлгэцийг ажиллуулах хуваарийг батлан бодлогын хэлтсүүдэд хариуцуулан үйл ажиллагааг тогтмолжуулж, “LCD дэлгэцийг ажиллуулах журам”-ыг шинээр батлан мөрдөн ажиллаж байна. Тус тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт мэдээллийн нэгдсэн самбар, салбарын хууль тогтоомж, бусад эрх зүйн акт, албан тушаалтнуудын холбогдох мэдээлэл бүхий танилцуулгыг албан ерөөний гадна байрлуулж, иргэдийг шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.</p>	100
<p>1.2.Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор жил бүр уламжлал болгон аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс албадын өргөн бүрэлдэхүүнтэйгээр сумдад аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулах ажлыг тогтмолжуулаад байна. Уг арга хэмжээг 2009 онд 9 сум, 2 тосгонд, 2010 онд 17 сум, 6 тосгонд зохион</p>	100

	байгуулж, иргэдэд эрэлт ихтэй, аймгийн төвд байрладаг төрийн үйлчилгээг сум, орон нутагт хүрч үйлчлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Энэ арга хэмжээнд давхардсан тоогоор 2009 онд 8462, 2010 онд 26257 иргэн хамрагдаж үйлчилгээ авсан байна. Аймгийн Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээгээр нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж, хөдөөгийн иргэдэд нэг дор эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртэх боломж олгодгоороо онцлогтой байдаг.	
1.3.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагын хууль, эрх зүйн ажил үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлж сайжруулах зорилгоор сумдын Засаг даргын Тамгын газруудад төрийн захиргаа, хууль эрх зүйн ажилтны ажлын байрыг шинээр бий болгож, дээрх ажилтнуудыг арга зүйн зөвлөмж, 30 гаруй төрлийн ном гарын авлагаар хангаж ажиллаж байна. Хууль, эрх зүйн ажил, үйлчилгээг сайжруулах зорилгоор холбогдох мэргэжилтэн, байгууллагуудад тусламж болгон “Хууль зүйн туслалцаа авах эрх” гарын авлагыг 500 хувь, 2010 онд “Эрх зүйн сургалт сурталчилгаа, туслалцаа, эмхэтгэлийг 300 хувь тус тус хэвлүүлэн сум баг иргэд олон нийтэд хүртээж хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны ажилд ашиглуулж байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх “Эрх зүйн туслалцааны төв”-ийн үйл ажиллагааг нь эхлүүлж 2009, 2010 онд 650 гаруй иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөх, 373 иргэнд эрх зүйн агуулга, ач холбогдол бүхий баримт бичгийн эх төсөл боловсруулж өгөх ажлыг хийж, төлбөрийн чалваргүй 60 гаруй хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлээд байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас эрх зүйн сургалт сурталчилгааны ажилд 2009 онд 800.0 мянган төгрөг, 2010 онд 3.0 сая төгрөг зарцуулж сум, багуудад нийтдээ 1000 гаруй ном, сурах бичиг, 120 гаруй зурагт хуудас, 85 сурталчилгааны диск, 3272 ширхэг нугалбар сурталчилгааны хуудсыг хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад дэмжлэг болгон түгээгээд байна. Сум орон нутагт хууль, эрх зүйн ажил үйлчилгээг сайжруулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх бодлогын хүрээнд “Хууль эрх зүйн ажил үйлчилгээнд баримтлах чиглэл шинэчлэн батлах, “Эрх зүйн ажлын дэвтэр хөтлөх, Эрх зүйн албан бус сургалтыг баг тус бүрт сар тутам зохион байгуулах, сар бүрийн 3 дахь 7 хоногийг иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх өдрүүд болгосон зэрэг ажлыг хийгээд байна. Дээрх ажил, арга хэмжээнүүдийг явуулсны үр дүнд 2009, 2010 онд аймгийн хэмжээнд нийтдээ эрх зүйн албан бус сургалтанд 23373 гаруй иргэд хамрагдаж эрх зүйн боловсролоо дээшлүүлсэн үр дүнд хүрээд байна.	100
1.4.Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эх хувиар Монгол Улсын Хууль зүйн, дотоод хэргийн яаманд эрх зүйн үндэслэлийг хянуулахаар тайлбарын хамт хүргүүлэн ажиллаж байна. 2009 онд 2, 2010 онд 1 захирамж, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг эрчимсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгох тухай” 20 дугаар тогтоолыг хянуулж улсын нэгдсэн бүртгэлд авахуулахаар тус тус хүргүүлсэн байна.	70

<p>1.5.Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;</p>	<p>Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас боловсруулж буй бодлогын томоохон баримт бичгүүдийг нутгийн иргэд, Сэлэнгэ аймгаас төрөн гарсан болон салбарын эрдэмтдийн санал, шүүмжлэлийг тусгах ажлыг тогтмол зохион байгуулж ирлээ. Сэлэнгэ аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тусгайлсан ажлын хэсэг байгуулан, төслийн шүүмжийг нутгийн эрдэмтдийн багаар хэлэлцүүлж, санал бодлыг тусган боловсруулсан. Мөн аймаг, сумын Засаг даргын захирамжилсан шийдвэрийн төслийг боловсруулахдаа урьдчилан санал авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлж хэвшсэн.</p>	<p>90</p>
<p>1.6.Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд нь иргэдийн санал, өргөдөл, гомдлыг тусгайлан байрлуулсан хайрцаг болон энэ чиглэлийн ажил хариуцсан мэргэжилтнээр дамжуулан тухай бүр хүлээн авч холбогдох албан тушаалтанд бүртгэл, хяналтын картаар дамжуулан танилцуулж, шуурхай шийдвэрлэхэд анхаарч ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд “Аймгийн нээлттэй хаалга” арга хэмжээг жил бүр хуваарь гарган бүх сумдад зохион байгуулж, энэ үеэрээ аймгийн удирдлагууд орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулан аймаг, орон нутгийн бодлого, зорилт, ажлын үр дүнгээ танилцуулан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг ажил тогтмолжсон. 2010 онд 17 сум 6 тосгоны 28.0 мянга гаруй иргэдтэй аймгийн Засаг дарга нүүр тулж уулзан санал хүсэлтийг нь хүлээн авч боломжтой асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэж, санал, хүсэлтийн шинжтэй асуултыг цаашид хэрэгжүүлэх бодлого, зорилтдоо тусган ажиллаж байна.</p>	<p>100</p>
<p>1.7.Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.</p>	<p>Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж ажиллах талаар сум, байгууллагын удирдлагуудад үүрэг чиглэл өгч хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 2010 онд ард иргэдээс төрийн байгууллагуудад нийтдээ 5033 санал, өргөдөл, гомдлыг ирүүлснээс 98.1 хувь буюу 4938-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь өгсөн.</p>	<p>100</p>
<p>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</p>		
<p>2.1.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Төрийн албаны дунд хугацааны шинэтгэлтэй уялдуулан иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чадах идэвхтэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий төрийн албыг төлөвшүүлэхэд орон нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагын чадавхийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, төр, төсвийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын зохистой үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хангуулах, ялангуяа төсвийн байгууллагын ерөнхий болон, нэгжийн менежер, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх арга хэмжээг шат дараатай зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2010 оны 359 дугаар захирамжаар сумдын Засаг даргын Тамгын газрын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үнэлж дүгнэх</p>	<p>90</p>

	журмыг шинэчлэн боловсруулж баталгаажуулан мөрдөж байна.	
2.2.Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;	Хүний нөөцийн удирдлагын ил тод нээлттэй байдлыг хангах талаар Сэлэнгэ аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн тэргүүлэх 4 стратегийн зорилт, Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд 10 зорилтыг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хамт тусган хэрэгжүүлж байна.	100
2.3.Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх;	Төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулан нийт 73 төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг хамруулснаас 2575 төрийн албан хаагчдын 73 хувь нь ямар нэг төрлийн сургалтанд хамрагдах хэрэгцээтэй байгаа нь тодорхойлогдсон. Иймээс төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлага нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанар, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлагыг үндэслэн “Төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар” хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдөн ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 110 тоот захирамжаар тухайн онд явагдах сургалт, семинар, зөвлөлгөөний нэгдсэн хуваарийг батлан хэрэгжүүлж ажилласнаар нийт 26 зөвлөгөөн, 25 сургалт семинар, 25 спортын уралдаан тэмцээн, 16 бага хурал, үзэсгэлэн худалдаа, уулзалт зэрэг нийт 89 ажил арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1200 гаруй төрийн албан хаагч, иргэд оролцлоо. 2009-2010 онд Удирдлагын академийн төрийн удирдлагын магистрийн сургалтанд 4, төрийн болон нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх менежерийн сургалтанд 11, богино хугацааны зорилтот сургалтанд 24, харъяалах дээд байгууллагын төлөвлөгөөт 182 удаагийн сургалтанд 892, нийт зохион байгуулагдсан сургалт семинарт давхардсан тоогоор 2566 төрийн албан хаагч хамрагдсан байна.	100
2.4.Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт ажилтнуудын аппаратын зөвлөгөөнөөр хүний нөөцийн зорилтын хүрсэн түвшинг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал, алдаа дутагдлыг засаж залруулах, дахин давтахгүй байх талаар байгууллагын дотоод асуудлыг нээлттэй хэлэлцэж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус зөвлөгөөний үр дүнд ажилтнуудын ажиллах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч, гарсан саналыг үндэслэн харилцан мэдээлэл солилцох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулж эхэлсэн нь ажилтнуудын хэрэгцээнд нийцсэн арга хэмжээ болж, үйл ажиллагаанд бодитой үр дүнгээ өгч байна. Мөн мэдээллийн цагийн арга хэмжээг нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад нэвтрүүлж, нийт сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд долоо хоногийн 1 өдөр байгууллагын шуурхай хурал, сонсгол, мэдээллийн цаг хэлбэрээр зохион байгуулж хэвшээд байна. Төрийн захиргааны албан хаагчдын ашиглаж буй техник хэрэгслийн судалгаа авч цаг үеийн шаардлагад нийцсэн үзүүлэлт бүхий компьютер 14, принтер-9, нийт 6 тосгон, 49 багийн Засаг дарга нарт-33 компьютер, 10 хэвлэгч, 11 хувилагч машиныг албан хэрэгцээнд нь олголоо.	100

<p>2.5.Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;</p>	<p>2009-2010 онд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтанд аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Хушаат, Жавхланта, Ерөө, Түшиг, Хүдэр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Хушаат, Зүүнбүрэн, Хүдэр Орхонтуул сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын албан тушаалын сонгон шалгаруулалтыг аймгийн “Сэлэнгийн мэдээ” сонин, мэдээллийн хэрэгслэлээр нийтэд нээлттэй байдлаар зарлан 7 удаа 13 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Аймгийн Боловсрол соёлын газраас 11 цэцэрлэг, 2 сургуулийн захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулан нийт 27 хүн хамрагдаж хамгийн өндөр оноо авч тухайн ажлын байрны ерөнхий шаардлагыг хангасан 13 хүнийг томилуулан ажиллуулж байна</p> <p>Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn болон аймгийн www.selenge.mn цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 2009-2010 онд нийт 936 хүн хамрагдаж, төрийн жинхэнэ албаны нөөцийн жагсаалтанд нийт 392 хүн бүртгэлтэй байгаагаас 140 хүн төрийн жинхэнэ албанд томилогдсон дүнтэй байна.</p>	<p>100</p>
<p>2.6.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.</p>	<p>2009-2010 онд аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдад 32292081.1 мянган төгрөгийн цалин, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулалд 1227537.6 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн албан хаагчдад 169814.1 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад 588388.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон дүнтэй байна. Мөн өөрийн салбартаа олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан 87 төрийн албан хаагчийг аймгийн Засаг даргын жуух, түүнийг дагалдах 1740.0 мянган төгрөгөөр урамшуулсан.</p> <p>Орон нутгийн төр төсвийн байгууллагад амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас “Төрийн албаны тэргүүний ажилтан”-аар 5, “Хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан”-аар 22, “Санхүү, банкны тэргүүний ажилтан”-аар 6, “Эдийн засгийн тэргүүний ажилтан”-аар 4, “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан”-аар 3 хүн тус тус шагнагдсан байна.</p> <p>Нутгийн захиргааны байгууллагын нийт 379 төрийн захиргааны албан хаагчдын 2010 оны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээгээр 45 хувь нь “маш сайн”, “сайн”, 52 хувь нь “хангалттай”, 3 хувь нь “дутагдалтай” гэж үнэлэгдсэнийг төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.</p> <p>2009-2010 онд төрийн захиргааны хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээгээр “А”, “В” үнэлгээ авсан ахлах, дэс, туслах түшмэлийн ангиллын 175 төрийн захиргааны албан хаагчид аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олголоо. Мөн Төрийн албаны зөвлөлд</p>	<p>100</p>

	уламжилснаар Ерөнхий сайдын захирамжаар аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт тэргүүн түшмэлийн дэд, дөтгөөр зэрэг дэв олгогдлоо.	
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал		
3.1.Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;	Аймгийн жил бүрийн төсвийн төслийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, заавар журмыг баримтлан төсвийн байгууллагуудын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилттой уялдуулан боловсруулсан саналыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах эрхэм зорилго, аймгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх стратегийн зорилтод нийцүүлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулан ажиллаж байна.	100
3.2.Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;	Аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэл, өглөг авлагын сар бүрийн болон жилийн эцсийн мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар www.selenge.mn цахим хуудсанд тогтмол байрлуулж нийтэд мэдээлж ажиллалаа. Мөн дээрх цахим хуудсаар дамжуулан 2010-2011 оны аймгийн төсвийн төсөлд иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгууллаа. Цахим хуудсанд байрлуулсан төсвийн төсөлтэй холбоотой санал ирүүлээгүй байна.	100
3.3.Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;	Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, аймгийн цахим хуудсанд, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээг өмнөх сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийн хамт дэлгэрэнгүйгээр байрлуулан сар тутам шинэчлэн иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг бүрлүүлэн ажиллаж байна.	100
3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	Аймаг сумдын орон нутгийн төсвийн болон салбарын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, аудитын дүгнэлт зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт байрлуулан иргэдэд хүргэж байна.	90
3.5.Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;	2009-2010 онд орон нутгийн төсвийн тодотголыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2-3 удаа тодотгон батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн мэдээлж ажилласан. Аймгийн тодотгосон төсвийг хэлэлцэж баталсан аймгийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, тогтоолын хавсралтуудыг аймгийн цахим хуудас болон орон нутгийн сонингуудад тухай бүр нийтэлж байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт байрлуулан тогтмол шинэчилж, тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд нээлттэй мэдээлж ажиллалаа.	100

<p>3.6.Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх;</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн тогтоолоор зарим төрлийн төрийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг зах зээлийн үнэ ханш, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлуулж тухай бүр мэдээллийн самбарын хууль, тогтоол шийдвэр танилцуулах буланд байршуулан нийтэд мэдээлж ажилласан.</p>	<p>100</p>
<p>3.7.Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Сэлэнгэ аймгийн төрийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чиглэл”-ийг батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус тогтоолоор 144 багцын 230 төрлийн үйлчилгээний чиглэлийг баталж, төрийн үйлчилгээний төрөл, төлбөр хураамж, болон шаардлагатай бусад мэдээллийн талаар нэг дор дэлгэрэнгүйгээр зохицуулж өгсөн. Цаг үеийн шаардлагаас үүдэн дээрх тогтоолыг шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулаад байна. Мөн хэлтэс, албад ажилтнуудын ажлын байрны чиг үүрэг, төрийн үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээ авахад иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, төлбөр хураамжийн тоо хэмжээ, холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг ил харагдахуйц газар байрлуулж төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлж хэвшлээ.</p>	<p>100</p>
<p>Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал</p>		
<p>4.1.Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх;</p>	<p>2010 онд Сэлэнгэ аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хуулийн дагуу, Сангийн сайдын тушаал журамын дагуу явагдаж Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 21 нэр төрлийн 6120.5 сая төгрөгийн ажил батлагдсанаас 16 нэр төрлийн 4519.9 сая төгрөгийн ажилд тендер шалгаруулалт явуулж 2 нэр төрлийн 440.0 сая төгрөгийн ажлын тендерийг 2009 онд явуулж 3 нэр төрлийн 1160.6 сая төгрөгийн ажлыг холбогдох сум, хэлтэс, агентлагт эрх шилжүүлэн тендер шалгаруулалт явуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил 100 хувь бүрэн дуусаад байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 100 нэр төрлийн 3216.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж үүнээс хөрөнгө оруулалтаар 34 нэр төрлийн 1655.2 сая төгрөг, их засварт 37 нэр төрлийн 1021.3 сая төгрөг, тоног төхөөрөмж 29 нэр төрлийн 540.3 сая төгрөг тус тус батлагдаж 93 нэр төрлийн 1640.4 сая төгрөгийн ажлыг холбогдох сум, хэлтэс, агентлагт эрх шилжүүлэн 7 нэр төрлийн 576.3 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг явуулж 1 нэр төрлийн 1000.0 сая төгрөгийн ажлын тендерийг 2009 онд шалгаруулан 100 хувь тендерийн ажил бүрэн дууссан. Орон нутгийн төсвийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 280.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж 6 нэр төрлийн 227.0 сая төгрөгийн ажлыг холбогдох сум, хэлтэс, агентлагт эрх шилжүүлэн Сүхбаатар сумын гэрэлтүүлгийн ажлыг нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгэлээ. Нийт 23 нэр төрлийн тендер шалгаруулалт явуулсан бөгөөд тендер тус бүрийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох Сангийн яамны www.e-procurement.mn сайтанд болон “Үнэн”, “Сэлэнгийн мэдээ” сонинд тендерийн үе шат бүрийг мэдээлж ямар нэг санал гомдолгүйгээр зохих шаардлагын хэмжээнд бүрэн хийсэн.</p>	<p>100</p>

<p>4.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх;</p>	<p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалт явуулах журам, тендерийн урилгыг хуульд заасны дагуу төвийн хэвлэл “Зууны мэдээ”, “Үнэн”, орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонинд тухай бүр нийтлүүлж ажиллалаа. 2010 онд нийт 23 тендерийн урилгыг сангийн яамны www.e-procurement.mn сайтанд олон нийтэд нээлттэй байршуулан тогтмол шинэчилж, холбогдох хууль, журмын дагуу шалгаруулалтыг зохион байгууллаа.</p>	<p>100</p>
<p>4.3.Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх;</p>	<p>Тайлант онд зарлагдсан нийт тендерийн үйл ажиллагааг төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөллийг тогтмол оролцуулан зохион байгуулсан болно.</p>	<p>100</p>
<p>4.4.Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх;</p>	<p>Сангийн сайдын 2007 оны 81-р тушаалаар батлагдсан тендерийн үнэлгээний заавар журмыг мөрдөн тендерт ирүүлсэн материалыг түүний төлөөлөгч болон сонирхсон этгээдийг оролцуулан зарласан хугацаандаа ил тод нээлттэй зохион байгуулж ирлээ. Аймагт зохион байгуулагдсан нийт 23 нэр төрлийн тендерт оролцохыг хүссэн иргэд, аж ахуйн нэгжид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох Засгийн газрын цахим хуудас www.e-procurement.mn сайт, болон орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонинд байршуулан мэдээлж ажилласан.</p>	<p>100</p>
<p>4.5.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх;</p>	<p>2010 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 23 нэр төрлийн 5096.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтанд тендер зарлан тендерийн урилгыг ил тод олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох /www.selenge.mn/ цахим хуудас болон “Сэлэнгийн мэдээ” сонинд байршуулж хуулийн дагуу хугацаанд нь тендерийг шалгаруулж, шалгарсан болон шалгараагүй шалтгааны талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж хуулийн хүрээнд гэрээ байгуулах эрх олгож “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон Сангийн сайдын баталсан 2007 оны 81 дүгээр журмын дагуу ажиллалаа.</p>	<p>100</p>
<p>4.6.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх;</p>	<p>Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан тендерийн үйл ажиллагааны талаар тухай бүр байгууллагын удирдлага, иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж, худалсан авсан бараа ажил үйлчилгээний явцын болон гүйцэтгэлийн тайланг аймгийн /www.selenge.mn/ цахим хуудаст байрлуулах, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж ажилласан.</p>	<p>100</p>
<p>4.7.Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх;</p>	<p>Тендер шалгаруулах явцад гарсан зөрчил болон шаардлага хангаагүй мэдээллийн талаар тухайн байгууллагад албан тоотоор мэдэгдэж харилцан холбоотой ажиллаж байна. 2010 онд тендерийн маргаантай гомдолтой үйл ажиллагаа гараагүй болно.</p>	<p>100</p>
<p>4.8.Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх;</p>	<p>2010 онд худалдан авах ажиллагаанд дагалдангаар суралцаж тендерийн үе шат болон хууль журмыг судлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тухайн асуудал хариуцсан ажилтанг Сангийн яамнаас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны чиглэлээр багшлах боловсон хүчнийг бэлтгэх болон сургагч багш нарын чадварыг нэмэгдүүлэх сургалтанд шат дараалан хамруулж, мэргэшүүлэх арга хэмжээг авлаа.</p>	<p>100</p>

<p>4.9.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх;</p>	<p>Сэлэнгэ аймгийн Аудитын газраас улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймагт хийгдсэн ажил үйлчилгээ холбогдох дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, явцын болон гүйцэтгэлийн тайлагналтанд хийсэн хяналт шалгалтаар “Дотоодын хяналтыг үр дүнтэй зохион байгуулсан” гэсэн үнэлгээ авч, шалгалтын дүнгийн талаар аймгийн “Сэлэнгийн мэдээ” сонин, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт байрлуулан нийтэд танилцуулах арга хэмжээг авсан.</p>	<p>100</p>
<p>4.10.Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх.</p>	<p>2010 онд тендерийн маргаантай гомдолтой үйл ажиллагаа гараагүй болно.</p>	<p>100</p>
<p>Дундаж</p>		<p>97.8</p>

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭЛ
/Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол/

2011.03.11

№	Агуулга	Нийт зорилтын тоо	Биелсэн	Хэрэгжих шатандаа	Үүнээс							Нийт хувь
					100%	90%	70%	50%	30%	10%	0	
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	7	5	2	5	1	1	-	-	-	-	94.3
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	6	5	1	5	1	-	-	-	-	-	98.3
3	Төсөв, санхүүгийн ил тод байдал	7	6	1	6	1	-	-	-	-	-	98.6
4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	10	10	-	10	-	-	-	-	-	-	100
	Нийт дүн	30	26	4	26	3	1	-	-	-	-	97.8

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР